

МУИС-ИЙН ОЮУТАН МОНГОЛЫН ИРЭЭДҮЙ

МУИС-ийн оюутан болсонд танд баяр хүргэе

Бид танд МУИС-ийн Ерөнхий суурь хичээлийн талаар товч мэдээлэл өгөхийг хүсч байна.

МУИС-ийн оюутан бүр нэгдүгээр түвшинд буюу эхний 2 улирал Ерөнхий суурийн хичээлүүдийг судална. Хэрэв та ШУС-ийн оюутан бол 36 багц цаг буюу 12 хичээл, ХЗС, ОУХНУС, БС, ХШУИС-ийн оюутан бол 30 багц буюу 10 хичээл судлах болно. Оюутан бүр 30 -аас доошгүй багц цагтай тэнцэх хичээлийг амжилттай судалсаны эцэст голч дүн болон элсэлтийн ерөнхий шалгалтын онооны дунджийн нийлбэр дүнгээр жагсаж, хамгийн өндөр оноотой оюутнаас эхлэн мэргэжлээ сонгох боломжтой болно.

Ерөнхий суурьтай холбоотой гардаг түгээмэл асуулт хариулт

Асуулт 1. Бидний эхний хоёр улирал судлах Ерөнхий суурь хичээл гэдгийг тодорхойлно уу?

Хариулт 1.

- Ерөнхий суурь хичээлүүд бол ерөнхий боловсролын сургуульд үзсэн хичээлийн давталт биш бөгөөд цаашид сонгон сурах мэргэжлийн нийгэм, хүмүүнлэг байгалийн ухааны суурь мэдлэг, ур чадварыг суулгах улмаар тодорхой чиглэлээр гүнзгийрэн сурах нөхцлийг хангасан ахисан түвшний судлагдхуун юм.
- Ерөнхий суурь хичээлийг судалснаар оюутан либерал арт боловсрол буюу нийгмийн идэвхтэй гишүүн байхад зайлшгүй шаардлагатай шүүмжлэлт, бүтээлч, логик сэтгэлгээнд суралцаж, санаачлан хийдэг, рациональ шинжлэх ухаанч шийдвэр гаргадаг, хөрвөдөг, нийгэм, хүмүүнлэг, байгалийн ухааны суурь мэдлэг, ур чадвар эзэмшсэн, их сургуулийн боловсролтой, чадварлаг, ёс зүйтэй иргэн болж хөгжинө.
- Ерөнхий суурь хичээл нь 100 хувь

Асуулт 2. Ерөнхий суурь хичээлийн зорилгыг тодорхойлж хэлнэ үү?

Хариулт 2.

- Ерөнхий суурь бол оюутанд дээд боловсрол олгоход зайлшгүй шаардлагатай шинжлэх ухааны үндэс буюу ойлгомжтой ярих, бичих, тоон болон тоон бус мэдээллийг боловсруулах, олон ургальч үзэл баримтлалын учир шалтгааныг таньж мэдэх; багаар үр дүнтэй хамтарч ажиллах, хариуцлагатай байх, харилцан суралцах мэдлэг, ур чадварыг заавал болон сонгон суралцах хэлбэрээр эзэмшүүлэх зорилготой бүлэг хичээл юм.

Асуулт 3. Ерөнхий суурь хичээлийг судалснаар оюутан бид ямар мэдлэг, ур чадвартай болох вэ?

Хариулт 3.

- Ерөнхий суурь хичээлүүд бол МУИС-ийн бакалаврын сургалтын суурь тулгуур орчин нөхцөл, тавигдах шаардлагыг хангахад чиглэсэн, 1. Нийгэм хүмүүнлэг, байгалийн шинжлэх ухааны суурь мэдлэг, 2. Аливаа мэдлэг туршлагаа амьдралд бүтээлчээр бодитой ашиглах ур чадвар олгох гэсэн үндсэн зорилтыг агуулсан академик, дээд боловсролын суурь мөн. Мэдлэг олгох зорилго бол амьдарч буй нийгэм, байгалийн орчны юмс үзэгдэл, харилцаа холбооны тухай шинжлэх ухаанч, рациональ мэдлэгтэй, логикоор сэтгэдэг бие хүнийг бэлтгэхэд чиглэдэг бол ур чадвар эзэмшсэнээр оюутан суралцагч өөрийн боловсрол, мэргэжлийн мэдлэг чадварыг амьдрал дээр амжилттай хэрэгжүүлэх ур чадвар эзэмшсэн, нийгмийн идэвхтэй гишүүн болж хөгжихөд тусална. Түүнчлэн ерөнхий суурь хичээлийг судалснаар оюутан өөрийн хүсэл сонирхол, авьяас чадварт тулгуурлан ирээдүйн мэргэжлээ ухамсартай сонгон сурах боломжтой болно.

Асуулт 4. Ерөнхий суурь хичээлүүдийг оюутан бид хэрхэн судлах вэ?

Хариулт 4.

- Шинээр элссэн оюутан бүрд Оюутны гарын авлага үнэгүй олгох ба тэндээс шаардлагатай бүх мэдээллийг авна. Түүнчлэн хичээлийн шинэ жилийн эхэнд хичээл сонгохоос өмнө Ерөнхий суурь хичээлийн видео болон бичмэл танилцуулгыг МУИС-ийн цахим хуудас, нийгмийн сүлжээ зэргээр түгээнэ.
- МУИС-ийн цахим хуудсанд www.num.edu.mn хаягаар орж Ерөнхий суурь хичээлийн Тодорхойлолт гэсэн хэсэгт буй хичээлийн тодорхойлолт бүрийг нэгбүрчлэн судлан танилцсаны дараа оюутан ямар хичээлийг сонгох вэ? гэдгээ шийднэ.
- МУИС-ийн оюутан Агуулгын чиглэл бүрээр заасан багц цагийг авахын тулд бүрэлдэхүүн сургууль, тэнхмүүдээс санал болгож байгаа хичээлүүдээс өөрийн судлахыг сонирхон судлахыг хүссэн хичээлийг СиСи- системээр сонгоно. Жишээ нь байгалийн ухааны 6 багц цагийг авахдаа санал болгож буй нийт хичээлүүдээс хүссэн 2 хичээлээ сонгож судалснаар энэ чиглэлийн шаардлага хангагдана.
- ШУС-ийн Ерөнхий суурийн багц цаг 36 багц байна. ХШУИС, БС, ОУХНУС, ХЗС-Ерөнхий суурийн нийт багц цаг 30 байна.
- Ерөнхий суурийн хичээлээр 50 болон түүнээс дээш оюутан сонгосон тохиолдолд бүлэг үүсгэнэ. Энэ шаардлагыг хангаагүй тохиолдол дахин сонголт хийлгэх, эсвэл ижил төстэй хичээлтэй нийлүүлэх эрхийг МУИС эдэлнэ. Гадаад хэлний хувьд сонгосон оюутны тоо 30 аас багагүй байна.
- Хэрэв танд хүндрэл учирвал Сургалтын албаны ажилтнуудад хандаж зөвлөгөө авна уу?

Асуулт 5. Ерөнхий суурь хичээл болон Мэргэжлийн (Major) хөтөлбөрийн уялдаа холбооны талаар хэлж өгнө үү?

Хариулт 5.

- Ерөнхий суурийн хичээлийг Мэргэжлийн хичээлийн багц цагт тооцох боломжтой. Тухайлбал Мат А, Мат Б, Мат В гэсэн түвшний хичээлийг Ерөнхий суурьт санал болгож, түүнээс оюутан Мат Б –г сонгон судалсан, тухайн хичээл Мэргэжлийн (Major) хичээлд мөн орсон бол оюутан энэ хичээлийн оронд Мат В юм уу эсвэл илүү ахисан түвшний математикийг\эсвэл мэргэжлийн өөр хичээлийг \ судлах боломжтой.
- Ерөнхий суурийн хичээлийн санал болгосон түвшинг хангасан болон илүү өндөр түвшний мэдлэгтэй оюутан нь тухайн хичээлийг тооцуулаад илүү ахисан түвшний хичээлийг\эсвэл өөр хичээлийг\ сонгон судлах боломжтой
- Зарим мэргэжлийн хөтөлбөрүүд Ерөнхий суурь хичээлээс санал болгож байгаа хичээлүүдээс түвшин зааж судалсан байх, эсбөгөөс тодорхой нэг хичээлийг заавал үзэхийг шаардсан байх боломжтой.

Асуулт 6. Ерөнхий суурь хичээлийн үнэлгээ хэр бодитой шударга байх вэ?

Хариулт 6.

- Ерөнхий суурь хичээлийн үнэлгээний тогтолцоо нь МУИС-ийн сургалтын журамд заасны дагуу зохицуулагдана. Шударга бус, субъектив үнэлгээнээс зайлсхийх үүднээс явц дундын болон улирлын шалгалтыг Тест хэлбэрээр авч тестийн машинаар засна. Ерөнхий суурийн хичээл зааж буй багш нар өөрийн хичээлээр хэд хэдэн хувилбар бүхий тестийг боловсруулах бөгөөд тэдгээрээс санамсаргүй түүврийн хэлбэрээр сонгож шалгалт авах, дүгнэх ажлыг СНА зохион байгуулна.
- Ерөнхий суурь хичээлийн явцад хөндлөнгийн эскпертүүд түүвэр байдлаар хичээлд сууж хичээлийн ерөнхий агуулга, танин мэдэхүйн үнэ цэнэ, ерөнхий суурийн хичээлийн шаардлагыг хангаж буй байдал, багшийн заах аргад үнэлгээ дүгнэлт өгнө.
- Ерөнхий суурь хичээлийн явцад оюутны бие даах ажлыг удирдан зөвлөгөө өгөх тогтмол цаг тогтоох бөгөөд хуваарийн дагуу багш\туслах багш нар оюутантай ажиллаж зөвлөгөө өгөх ажлыг улирлын турш зохион байгуулна.
- Түүнчлэн Ерөнхий суурь хичээл судалж буй оюутан бүрээс судалж буй хичээлийн чанар, багш нарын ур чадвар, хариуцлагатай байдлын талаар санал асуулга авч гарсан үр дүнд тулгуурлан шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

МУИС-ийн Хөтөлбөрийн Ерөнхий хороо
МУИС-ийн Сургалтын нэгдсэн алба